



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/377

Есөнбулаг

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Баянхайрхан багийн Солонго хорооллын нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан 30 айлын орон сууцны барилгыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Д.Отгонжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Цэрэндаваа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)
	Ш.Ариунаа	(Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны аймгийн зөвлөл)
	Д.Нямжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн

ажлын албаны архитектур,  
барилга, нийтийн аж ахуй  
хариуцсан мэргэжилтэн)  
Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ"  
ТӨХК-ийн ерөнхий инженер)  
Д.Баярчулуун ("Алтай-Улиастайн эрчим хүчний  
систем" ТӨХК-ийн ерөнхий  
инженерийн албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)  
Г.Хүрэлхүү ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын  
ерөнхий инженер)  
Д.Содномдаржаа ("Солонго дулааны станц"  
ААТҮГ-ын ерөнхий инженер)  
Ч.Нарандэлгэр ("Барилга байгууламж" ХХК-ийн  
захирал) (зохиогч)  
Б.Ганбаатар ("Босго толгой" ХХК-ийн захирал)  
(гүйцэтгэгч)  
Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхцэцэг ("Алтай орон сууны корпораци"  
ААТҮГ-ын инженер) (захиалагч)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн хүлээн авч, үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ



